

**“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар №. 07

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүдийг чөлөөлж, томилох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/5918 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүнээр ажиллаж буй энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад нэр заасан гишүүдийг үргэжлүүлэн ажилуулахаар тогтоосугай.

2.“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүнээр ажиллаж буй энэ тогтоолын хоёрдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

3.“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус энэ тогтоолын гуравдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн томилсугай.

4.Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргаж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ**

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ

ТӨЛӨӨЛЖ:

Б.НАСАНТОГТОХ

УХА0558


ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ

ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0998169 & 1118262


Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны 04 дүгээр сарын 22 ний өдрийн
0.7 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ
БУС ГИШҮҮНЭЭР ҮРГЭЛЖЛҮҮЛЭН АЖИЛЛАХ ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Л.Дарамбазар
2		Ц.Тунгалаг


Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
09 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ
БУС ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Г.Бэхбат

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
07 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт



"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ
БУС ГИШҮҮНЭЭР ТОМИЛОГДОХ НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Б.Хэрлэнчимэг